

ТЭРГҮҮН

ХЯТАДЫН АРД ТҮМНИЙ ИХ БАЯР

40 жилийн тэртээ, 1949 оны 10-р сарын 1-нд БНХАУ байгуулагдсан билээ. Тэр өдөр хятадын ард түмний олон жилийн турш хийсэн хувьсгалт тэмцэл ялалтаар дуусч, Шинэ Хятад улс байгуулагдсаныг дэлхий дахинаа зарлан тунхагласнаар эрх чөлөөгөө олсон ард түмний их баяр болж БНХАУ-ын түүхэнд тэмдэглэх болсон юм. ХКН-ын удирдлагаар Хятадын ард түмэн хагас колони, хагас феодалын дарлалыг таягдан хаяж, улс орныхоо олон зууны түүхэнд шинэ хуудас нээж, социалист хөгжлийн замд орлоо.

Аливаа дарлал мөлжлөгөөс чөлөөлөгдөх замыг хүн төрөлхтний өмнө нээсэн аугаа их Октябрийн социалист их хувьсгалын нөлөө, марксизм-ленинизмийн тугийн дор Хятадын хувьсгал өрнөж, 20 гаруй жилийн хүнд бэрх тэмцлийн дүнд ялалтанд хүрчээ. ХКН дэлхийн хувьсгалт хөдөлгөөнтэй нягт холбоотой байсны үрээр нийгмийн болон үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэлд хүн амын өргөн олон давхаргыг нэгтгэж чадсан байна. Хятадын хувьсгалыг анх үүсэхээс нь эхлээд олон улсын коммунист хөдөлгөөн, ялангуяа ЗХУ асар их тусламж үзүүлж, ямагт дэмжиж байлаа. Хятадын ард түмний олон жилийн баатарлаг тэмцлийг анги, зорилго нэгт Монголын ард түмэн цаг ямагт талархан дэмжиж, эд материалын болон сэтгэл санааны тусламж үзүүлж байв. Дэлхийн 2-р дайнд ЗХУ болон түүний холбоотнууд Германы фашизм, Японы милитаризмыг бут цохисон түүхэн ялалтын үрээр Хятадын хувьсгал ялах гадаад улс төрийн нэн таатай урьдчилсан нөхцөл бүрэлдсэн юм. Зөвлөлт, Монголын хамтарсан хүч 1945 онд Квантуны армийг бут цохиж Зүүн Хойт Хятад, Өвөр Монголыг Японы дарлалаас чөлөөлсөн нь Хятадын хувьсгалд шийдвэрлэх чухал ач холбогдолтой байлаа.

Хятадад ялан мандсан ардын хувьсгал нь дэлхийн хувьсгалт үйл явцын нэгэн хэсэг болж, Ази дахь империализмын байр суурьт хүчтэй цохилт болсоноор олон улсын тавцан дахь хүчний харьцааг энх тайван, социализмын талд ашигтайгаар өөрчлөн, эрх чөлөө үндэсний тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж байсан Ази, Африкийн дарлагдсан улс түмний тэмцэлд үлэмж түлхэц өгсөн юм.

БНХАУ байгуулагдсанаас хойшхи өнгөрсөн 4 арван жилийн энэ хугацаа бол Хятадын ард түмний түүхэнд ялалт, амжилтын, мөн ч онцгой түвэгтэй, хүнд бэрх, зөрчилтэй үйл явдлын үе байлаа. Ард түмнийхээ амь хайргүй хөдөлмөр тэмцэл, ЗХУ болон социалист бусад орны эв санааны нэгдэл, бүх талын тусламжийн үрээр БНХАУ социалист байгуулалтынхаа эхний 10 жилд гайхамшигт амжилт олж байв.

Тус оронд нийгэм-эдийн засгийн чухал чухал өөрчлөлт хийгдэж социализмын материал техникийн бааз байгуулагдан, үйлдвэрлэх хүчин түргэн хурдацтай хөгжиж, хятадын олон үндэстний ард түмний материаллаг аж байдал, соёлын түвшин үндсээрээ өөрчлөгдөж, БНХАУ-ын нэр хүнд, байр суурь олон улсын тавцанд бэхжсэн юм.

1956 оны 9-р сард хуралдсан ХКН-ын VIII их хурлаас тус оронд социализм байгуулах жанжин шугамыг баталсан нь түүхэн чухал ач холбогдолтой байлаа. Тус хурлаас марксизм-ленинизмийн сургаалыг удирдлага болгон, дэлхийн социализмын туршлагыг хятадын өвөрмөц онцлогтой нягт холбон, орчин үеийн үйлдвэр, өндөр хөгжсөн хөдөө аж ахуй, тэргүүний соёл шинжлэх ухаан бүхий Социалист Хятад улс байгуулахыг тодорхойлон заасан нь бүх ард түмний өргөн дэмжлэ-

гийг хүлээж байв. Их хурал ЗХУ болон социализмын бусад орнуудтай ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаагаа өргөтгөж, Ази Африкийн улс орнуудтай нөхөрсөг харилцаагаа хөгжүүлэх, империализмын эсрэг тэмцэх явдлыг БНХАУ-ын гадаад бодлогын үндсэн чиг шугам мөнийг тэмдэглэжээ.

60-аад оныг хүртэл БНХАУ энхийг эрхэмлэгч улс орнуудтай хамт олон улсын амин чухал асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах, нийгмийн янз бүрийн байгуулалттай улс орнууд энх тайвнаар зэрэгцэн орших, колоничлолыг бүрмөсөн устгахын төлөө тууштай тэмцэж байв.

Эдгээр жилүүдэд монгол, Хятадын харилцаа пролетарийн интернационализмын зарчмын үндсэн дээр амжилттай хөгжиж байв. Энэ найрамдалт харилцааг 1960 оны 5-р сард байгуулсан БНМАУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, харилцан туслалцах гэрээгээр батжуулан бататгасан юм. БНМАУ империалист харгис хүчнийхэний БНХАУ-ыг ганцаардуулах, үндэсний эрх ашгийг нь хохироох, олон улсын амьдралд идэвхитэй оролцоход саад хийх гэсэн аливаа оролдлогыг эрс эсэргүүцэж байлаа.

Хятадад гарсан «Соёлын хувьсгалын» уршигаар тус орны нийгэм эдийн засгийн хөгжил ихэд хохирч, нийгмийн хүнд бэрх хямралд учирч, ард түмний аж байдал эрс бууран доройтсон юм. Түүгээр ч барахгүй социализмын их гэр бүлээс тасран холдож, Зөвлөлтийн эсрэг үзлийг хөөргөн дэвэргэж улмаар империализмтай хамтран ажиллаж, тэднийг аялдан дагалдахад хүрч байв. Ийм чиг шугам хятадын ард түмний язгуур эрх ашигт төдийгүй энх тайван, социализмын үйлст ноцтой хохирол учруулж байлаа.

Гэвч 70-аад оны сүүлч үеэс эхлэн Хятадын бодлогод өөрчлөлт гарч эхэллээ. ХКН-ын 1978 оны XII сарын бүгд хурлыг БНХАУ-д түүхэн эргэлтийн үйл явдал гэж үнэлж байна. Энэ бүгд хурлаас нам, төрийн бүх ажлын голыг эдийн засгийн бүтээн байгуулалтанд шилжүүлэх шийдвэр гаргасны үндсэн дээр 4 шинэчлэлтийг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэл Хятад орон даяар өрнөв. Өөрөөр хэлбэл ХКН-ын 1978 оны III бүгд хурлаас хойш тус орон түүхийн шинэ үед, эдийн засгийн шинэтгэлийн үе, гадаад ертөнцтэй харилцаагаа өргөжүүлэх үедээ орлоо.

Хятадад нийгэм-эдийн засгийн өргөн хүрээтэй өөрчлөн байгуулалтыг хөдөө аж ахуйгаас эхэлжээ. 80-аад оны эхнээс Хятадын хөдөө аж ахуйд гэрээ түрээс хариуцлагын систем нэвтэрч, үйлдвэрлэлийн хэрэгслийн дийлэнхийг тариачдын аминд шилжүүлэх зэрэг арга хэмжээ авлаа. Хөдөөд явуулсан шинэтгэлийн үрээр Хятадын хүн амын дийлэнх олонхийн аж амьдрал дээшилжээ. 1979 онд Хятад улс жилд 300 сая тонн үр тариа хураан авч байсан бол 1984 онд 400 сая тонн д хүрч, 1984 оноос эдийн засгийн шинэтгэлийг хотод явуулж тодорхой үр дүнд хүрлээ. Одоо Хятадад улсын өмчийг гол болгосон олон хэвшилт эдийн засаг хэлбэршин тогтлоо. 1988 онд аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд бүх ард түмний өмч 56,8%, хамтынх 36,2%, аминых 4,3% бусад (хамтарсан үйлдвэр г. м) 2,7% эзэлж байна.

1988 оны байдлаар БНХАУ-ын үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гол бүтээгдэхүүний хэмжээг хувьсгалаас өмнөх Хятад орны эдийн засгийн хамгийн өндөр үзүүлэлттэй жишиж үзвэл нүүрс олборлолт 16 дахин өсч 970 сая тонн, ган хайлуулалт 64 дахин өсч 59 сая 180 мянган тонн, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлт 91 дахин нэмэгдэж 545 миллиард квт цаг, нефть гаргалт 428 дахин нэмэгдэж 137 сая тонн-д хүрсэн байна. Өөрөөр хэлбэл Хятад улс өнөөдөр дэлхийн түвшинд нүүрс олборлолтоор 1-р байр, ган, цахилгаан, нефть үйлд-

вэрлэлээр 4, 5, 6-р байранд байна. Мөн үр тариа, хөвөн, бөс барааны үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлж байна.

Хятад улс дэлхийн хүн амын 22%-ийг буюу 1 миллиард 100 сая ард түмнийхээ дийлэнх олонхийн идэх уух, өмсөх зүүх асуудлыг шийдвэрлэж, ХКН-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийн гол зорилтыг амжилттай хэрэгжүүлж байна. Хятадын ард түмний аж байдал, соёлын хэмжээ хүнс, орон сууцны хангамж, сайжирсаар байна.

БНХАУ-ын “Нээлттэй байх” бодлого амжилттай хэрэгжихийн хирээр тус оронд эдийн засгийн онцгой район, нээлттэй хотууд бий болж, гадаадын тэргүүний техник технологи, аж ахуйг эрхэлж хөтлөх дэвшилт арга нэвтэрч, гадаадын капиталыг их хэмжээгээр ашиглаж, дотоодын эдийн засгийн байгуулалтанд үзүүлэх үр нөлөө нь улам бүр өсч байна.

БНХАУ олон улсын тавцанд энх тайванч, хараат бус бие даасан гадаад бодлого баримталж, энх тайван, улс түмний найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. Энэ нь хятадын ард түмний эрх ашиг, социализмын мөн чанар, нийт хүн төрөлхтний нийтлэг хүсэл зорилгод нийцэж байна.

Социализмын анхан шатанд байгаа тус орны өмнө социализмыг хөгжүүлэн боловсронгуй болгох, эдийн засгийн хүчин чадлаа зузаатгах, ард түмнийхээ аж байдал соёлын хэмжээг жигдрүүлэх, үйлдвэрлэлийн техник технологийг шинэчлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зэрэг зорилт тулгарч байна.

ХКН-ын удирдлагаар социализм байгуулж буй хятадын хөдөлмөрчин ард түмэн улс орондоо нийгэм-эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт хийж, шинэтгэлийн өргөн цар хүрээтэй бодлогоо амжилттай хэрэгжүүлж байна. БНХАУ байгуулагдсан 40 жилд Хятадын ард түмний олсон ололт амжилт бол социализмын ололт амжилт мөн. Хятад дахь социализм хөгжлийн янз бүрийн бэрхшээл туулж, алдаж онож байсан хэдий ч хагас колони, хагас феодалын хятад орныг социалист хөгжлийн замд гаргалаа. Социалист байгуулалтын өвөрмөц онцлог бүхий Хятадын социализмын туршлага, сургамжийг социализмын ертөнц бүхэлдээ анхааран үзэж байна.

ХКН-ын XIII их хурлынхаа шийдвэрээр Хятадын ард түмэн социалист, шинэчлэлтийг хэрэгжүүлэхийн төлөө хүчээ төвлөрүүлж эрчимтэй хөдөлмөрлөж байна. Тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлэх нь Хятадын нийгэм-эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, ард түмний аж байдлыг улам чинээлэг болгох, БНХАУ-ын олон улсын харилцаанд эзлэх байр суурийг нэмэгдүүлэхэд тус дөхөм болох билээ.

Хятадын хөдөлмөрчин ард түмний их баяр БНХАУ-ыг тунхагласны 40 жилийн ойг тохиолдуулан Монголын ард түмэн найрамдалт хөрш Хятадын ард түмэнд ХКН-ынхаа удирдлагаар социалист шинэтгэлийн үйлсдээ шинэ шинэ амжилт олохыг хүсэн ерөөж, хоёр орны уламжлалт найрамдал улам хөгжинө гэдэг итгэлээ илэрхийлж байна.